



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2021 оны 07 сарын 02 өдөр

Дугаар 16

Эрдэнэт

Иргэний зөвлөлийн зарим гишүүнийг
чөлөөлж, томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэг, 19 дүгээр зүйлийн 19.1.4 дэх заалт, Цагдаагийн албаны тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.4 дэх хэсэг, Хууль зүйн сайдын 2017 оны А/133 дугаар тушаалаар батлагдсан "Иргэний зөвлөлийн дүрэм"-ийн 3.2.7 дахь заалт, Иргэний зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах комиссоос зохион байгуулсан дүнг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ээлжит бус II хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Иргэний зөвлөлийн гишүүнээр ажиллах хугацаа нь дууссан З.Баттулга, Т.Батзоригт нарыг 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн Иргэний зөвлөлийн гишүүнээс чөлөөлсүгэй.

2.Хамгийн олон санал авсан Н.Ганболд, Т.Батзоригт нарыг 2021 оны 07 дугаар сарын 02-ны өдрөөс эхлэн 3 жилийн хугацаагаар томилсугай.

3.Үйл ажиллагаагаа холбогдох хууль, дүрмийн дагуу явуулж, жил бүрийн тайланг дараа оны 01 дүгээр сард багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнаж байхыг Иргэний зөвлөлд даалгасугай.

ДАРГА



Д.МӨНХБАТ